



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/52

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн "Баянгол шинэ өргөө"
ОНӨААТҮГ-ынданс бүртгэлээс
тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/61 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Ашиглалтын шаардлага хангахгүй болж, засаж сэлбэх нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдахаар шийдвэрлэгдсэн 117,500,000 (нэг зуун арван долоон сая таван зуун мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан тээврийн хэрэгслүүдийг акталж, данс бүртгэлээсээ хасахыг Баянгол дүүргийн "Баянгол шинэ өргөө" ОНӨААТҮГ (Ж.Галтбаяр)-т зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслүүдийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийх, тээврийн хэрэгслүүдийн гэрчилгээ, улсын дугаарыг хураан авч, авто тээврийн улсын бүртгэл болон татварын бүртгэлээс хасуулахыг Баянгол дүүргийн "Баянгол шинэ өргөө" ОНӨААТҮГ (Ж.Галтбаяр)-т үүрэг болгосугай.


3.Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Захиргаа, төлөвлөлт, санхүүгийн хэлтэс (Б.Батбаяр)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

ДАРГА  М. БАЯРАА



115050000151

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
 2022 оны 02 сарын 17-ны өдрийн
 А/52 тушаалын хавсралт



СЭЛБЭГИЙН БУЮУ ХОЁРДОГЧ ТҮҮХИЙ ЭДИЙН ЗОРИУЛАЛТААР ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЖ
 ХУДАЛДАХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

/төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Автомашины марк, улсын дугаар	Үйлдвэрлэсэн/ Монголд ашиглаж эхэлсэн он	Зориулалт, аль улсад үйлдвэрлэсэн, өнгө	Арлын дугаар	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Эвдрэл гэмтэл
1	Баянгол дүүргийн "Баянгол шинэ өргөө" ОНӨААТҮГ	LW300F Ковш 19-30 УБ	2011/2011	Тусгай БНХАУ Шар	11109078	17000	79,800,000	Техникийн комиссын дүгнэлтээр тээврийн хэрэгсэлд тавигдах техникийн шаардлага хангахгүй, цаашид ашиглах боломжгүй, засвар авах боломжгүй, ашиглалтын хугацаа дууссан тул акталж данснаас хасах
2		Тоёота эстима 26-77 УБЕ	2002/2014	Суудал ЯПОН Цэнхэр	AHR1000083 46	171000	6,000,000	
3		Дэу автобус 17-62 УНО	1995/2008	Суудал БНСУ Улаан алаг	KLUDTCSP0 05174	442864	5,000,000	
4		Донг фенг EQ 05-94 УНН	2002/2010	Тусгай БНХАУ Цэнхэр	EQ196162D2 X972069	164168	26,700,000	
нийт							117,500,000	